

ХАВДАР СУДЛАЛЫН САЛБАРЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

No	Төслийн нэр, дугаар			Төсөл хэрэгжүүлэгч болон хамтран хэрэгжүүлэгч байгууллага	Төслийн зорилго	Хэрэгжих хугацаа		Санхүүжүүлэгч байгууллага	Санхүүжилтийн хэлбэр
	Төслийн нэр /Монгол/	Төслийн нэр /Англи/	Дугаар			Эхлэх огноо	Дуусах огноо		
1	Умайн хүзүүний хавдрын дотуур эмчилгээний гурван хэмжээст дүрслэлд суурилсан аргын үр дүнг судлах нь (АЦХАФ)-ын умайн хүзүү-V олон төвт эмнэл зүйн судалгаа/	3D-Image-guided brachytherapy for Locally Advanced cervical cancer (Cervix-V)	Байхгүй	Япон улсын Засгийн газрын санаачилгатай байгууллага буюу Азийн Цөмийн Хамтын Ажиллагааны Форум (FNCA), ХСҮТ	АЦХАФ-ын гишүүн орнуудын дунд умайн хүзүүний хорт хавдрын хэсэг газартаа даамжирсан үе шатанд 3 хэмжээст дүрслэлд үндэслэсэн дотуур туяа эмчилгээний үр дүнг тодорхойлох I үр дүн: 2 жилдээ нийт амьдрах чадамж II үр дүн: 2 жилдээ хэсэг газрын үр дүн	2019	2025	Япон улсын Засгийн газар	Байхгүй

2	Стереотактик туяа эмчилгээний аргыг шинээр нэвтрүүлэх замаар Монгол улс дахь нийтлэг хорт хавдрын туяа эмчилгээний чанарыг сайжруулах нь” ОУАЭА-ийн MON/6021 төсөл	“Improving the Quality of Radiotherapy Services for Common Cancers through the Implementation of Linear Accelerator Based Stereotactic Body Radiation Therapy”	MON602 1	1. Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА), 2. Монгол улсын Засгийн газар 3.ХСҮТ	“Монгол Улсад Стеореотактик туяа эмчилгээг зонхилон тохиолдох хавдруудад нэвтрүүснээр эмчилгээний үр дүн, хүртээмжийг сайжруулах нь”	2020	2023	1. ОУАЭА 2. МУЗГ	ОУАЭУ-буцалтгүй тусламж, МУЗГ-Австрийн засгийн газрын хөнгөлөлттэй зээл, улсын төсвөөс
3	Шугаман хурдасгуурт суурилсан дэвшилтэт технологи нэвтрүүлснээр хорт хавдрын туяа эмчилгээний чадавхийг сайжруулах төсөл	Improving Radiotherapy Capacity Through Introducing Linear Accelerator Based Advanced Technologies	MON602 2	1.Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА), 2.ЦЭКАА	Шугаман хурдасгуурт суурилсан дэвшилтэт туяа эмчилгээг нэвтрүүлж чанарын хяналтыг сайжруулсанаар хавдартай өвчтнүүдийн туяа эмчилгээний чанарыг сайжруулах	2022	2023	ОУАЭА	Хөнгөлөлттэй зээл

4	Умайн хүзүүний хавдрын дүрслэлд суурилсан дотуур туяа эмчилгээг хэрэглэх, чанарын баталгааг сайжруулах төсөл	Image-guided brachytherapy in the treatment of cervical cancer: an implementation study	E33042	Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА), ЦЭКАА	Умайн хүзүүний хавдрын дүрслэлд суурилсан дотуур туяа эмчилгээг хэрэглэх, чанарын баталгааг сайжруулах	2021	2024	ОУАЭА	Буцалтгүй тусламж
5	Хорт хавдрын навигаци болон стереотактик эмчилгээний төв байгуулах төсөл	Establishment of cancer center of navigation and stereotactic treatment center	Байхгүй	1.Австрийн Засгийн газар 2.Монгол улсын Засгийн газар, ЭМЯ 3.ХСҮТ	1. Тархи нугасны хавдартай иргэдэд орчин үеийн цогц оношлогоо, эмчилгээг нэг дор үзүүлэх зорилгоор Нейро-онкологийн төв байгуулж, тархи, нугасны хавдрын тусламж үйлчилгээг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх 2. Манай оронд зонхилон тохиолдох хавдруудын туяа эмчилгээг олон улсын түвшинд хүргэх, чанар, хүртээмжийг нь сайжруулах	2021	2023	1. Австри улсын ЗГ 2. МУЗГ	Зээл тусламж

6	Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг байгуулах төсөл	A project to establish a national network on cancer prevention and early detection	Байхгүй	1. Австри улсын Засгийн газар 2. Монгол улсын Засгийн газар (ЭМЯ) 3.ХСҮТ	Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний тогтолцоог бий болгох	2021	2024	1. Австри улсын ЗГ 2. МУЗГ	Хөнгөлөлттэй зээл
7	RCA-ийн гишүүн орнуудын туяа эмчилгээний хүртээмжийн тэнцвэргүй байдлыг арилгах төсөл	Estimation of Radiotherapy service in Mongolia and defining roadmap planning to improve it	RCARP0 3	1.Олон улсын атомын энергийн агентлаг (ОУАЭА), 2.Бүсийн хамтын ажиллагааны хэлэлцээр, 3.ЦЭКАА 4.ХСҮТ	Монгол улс дахь туяа эмчилгээний одоогийн байдлыг үнэлж цаашид сайжруулах арга замыг тодорхойлох	2022	2024	ОУАЭА, Бүсийн хамтын ажиллагааны хэлэлцээр	Буцалтгүй тусламж

Санхүүжүүлэх төсөв сая.төг		Төслийн захирал, зохицуулагч	Төслийн үндэслэл, хэлбэр	Төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил, үр дүн, тайлан	Гүйцэтгэл хувь	Санхүүжүүлсэн төсөв сая.төг		No
Валют	Санхүүжилт					Валют	Санхүүжилт	
Байхгүй	Тусгайлсан төсөвгүй	Ц.Уранчимэг (ХСҮТ-ийн ҮАЭ дэд захирал)	Монгол улс 2012 онд АЦХАФ-ийн гишүүн орон болж, Азийн 10 гаруй улсын туяа эмчилгээний институтийг хамарсан ОУ-ын хамтарсан эмнэлзүйн судалгаанд ХСҮТ 2013 оноос тогтвортой оролцож эхэлсэн.	АЦХАФ-ын олон улсын хамтарсан "CERVIX-V" судалгаанд оролцон 4 тохиолдлыг амжилттай эмчилж, бүртгүүлээд, зохих хяналтыг хийсэн. Энэхүү судалгаанд хамруулах зорилтот өвчтөний тоондоо хүрсэн тул, шинээр өвчтөний бүртгэлийг 2023 онд хаасан. АЦХАФ-ын Туяа эмчилгээний төслийн 2023 оны уулзалт хурал Япон улсад зохион байгуулагдах үеэр энэхүү судалгаанд хамруулсан өвчтөнүүдийн хяналтыг дараагийн 2 жилд судалгааны протоколын дагуу үргэлжлүүлэхийг судлаачдад мэдэгдлээ.	100%	Байхгүй	Байхгүй	1

EUR	1,263,365.0	Н.Эрдэнэхүү (ХСҮТ-ийн Ерөнхий захирал) Ц.Уранчимэг (ХСҮТ-ийн ҮАЭ дэд захирал)	Стереотактик туяа эмчилгээ нь хавдартай өвчтөнд унтуулга, мэдээ алдуулалт хэрэглэхгүй бөгөөд мэс заслын шарх, зовиур үүсгэхгүй, эрт үеийн хорт хавдруудад мэс засалтай ижил үр дүнд хүргэдэг инвазив бус эмчилгээний арга юм. Энэ нь ердийн туяа эмчилгээтэй харьцуулахад маш өндөр нарийвчлалтай буюу хавдрыг 1мм-ийн ч алдаагүйгээр цацрагаар онилж буудан, нэг удаад өндөр тунгаар цөөхөн удаа хийнэ.	1. Тоног төхөөрөмжийн худалдан авалт 2. <u>Хүний нөөц бэлтгэх</u> : Эмч (3), техникч (2) нарыг чадавхжуулах зорилгоор 3-6 сарын хугацаатай сургалтад хамруулсан. Одоо 1 эмнэлгийн физикч 2024 оны 3 сард дуусах 6 сарын хугацаатай сургалтад хамрагдаж байна. Байгууллагын удирдлагын танилцах дадлага 2023 оны 2 сард Японы Хирошимагийн их сургуульд амжилттай хийгдсэн. 3. <u>Протокол боловсруулах</u> : Элэг, уушгины хавдрын протоколыг боловсруулж байгаа бөгөөд энэ төрлийн хавдарт стереотактик туяа эмчилгээг 2024 оны 2-р улиралаас хийж эхэлнэ.	90%	1263365 EUR	Санхүүжилт дууссан	2
EUR	940,190.0	Н.Эрдэнэхүү (ХСҮТ-ийн Ерөнхий захирал), М.Минжмаа (ХСҮТ-ийн ТЭТ-ийн эрхлэгч)	Монгол улсад тархи, нугас, дахисан болон үсэрхийлсэн хавдрууд, уушиг, нойр булчирхай, хамгийн их тархалттай элэгний хавдрын зарим тохиолдолд дэвшилтэт туяа эмчилгээ нэвтрээгүйгээс уг тусламж шаардлагатай өвчтөнүүд гадаад улс оронд өндөр зардлаар эмчлүүлж байна.	1. 2023 оны 3 сард ОУАЭА-ийн төсөл хариуцсан мэргэжилтэн Даниел Бергер ирж ажиллан төслийн явцтай танилцсан. 4 сард хийгдсэн ОУАЭА-аас томилогдсон эксперт Японы эмч Кен Андогийн айлчлалын үеэр 2 үе шаттай Дүрслэл суурилсан дотуур туяа эмчилгээний үндэсний семинар зохион байгуулсан. 2. 1-2 сарын феллоушип сургалтад 4 эмч мэргэжилтэнийг Австрали улсад 4 хэмжээст болон Стереотактик туяа эмчилгээний чиглэлээр, 3 эмч мэргэжилтэнийг Энэтхэг улсад эд завсрын дотуур туяа эмчилгээний чиглэлээр	70%	EUR	10,250.0	3

EUR	2,000.0	В.Энхцэцэг (ХСҮТ-ийн ТЭТ-ийн Физикч инженер)	Монгол улсад умайн хүзүүний хорт хавдартай өвчтөнд хийгдэж байгаа дотуур туяа эмчилгээний үр дүнг олон улстай харьцуулж, эмчилгээний баталгаажилтын түвшинг тогтоох, цаашид эмчилгээний үр дүнг нэмэгдүүлэх арга замыг боловсруулах шаардлагатай.	Умайн хүзүүний хавдрын дүрслэлд суурилсан дотуур туяа эмчилгээг хэрэглэх, чанарын баталгааг сайжруулахад шаардлагатай санхүүжилтийг хүн амд суурилсан байдлаар бодитоор тооцоолох олон институтыг хамруулсан судалгааны асуумжууд хийгдсэн.	100%	EUR		4
EUR	7.000.000	Н.Эрдэнэхүү (ХСҮТ-ийн Ерөнхий захирал)	Монгол улсад тархи нугасны хорт хавдрын тусламж үйлчилгээ хөгжөөгүйгээс өвчтөнүүд хавдрын хожуу үе шатандаа оношилогддог ба гадаад улс оронд өндөр зардлаар эмчлүүлэх шаардлагатай болдог.	1. <u>Тоног төхөөрөмжийн хангалт</u> : Төсөл хэрэгжүүлэгч Вамед компани мэдрэлийн мэс заслын 12, туяа эмчилгээний 8 нэр төрлийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, угсралт суурилуулалт хийгдэж, ашиглалт 90 хувьтай, хүлээн авах бэлтгэл хийгдэж байна. 2. <u>Хүний нөөцийг бэлтгэх</u> : Мэдрэлийн мэс заслын 2 болон туяа эмчилгээний 1 эмчийг Тайвань улсад 1.5 сарын сургалтанд 2022 оны 12 сарын 1-ээс төслийн бус санхүүжилтээр хамруулсан. Мөн УГТЭ дээр дагалдан сургалтанд хамруулж байна. Эмч, мэргэжилтнүүдэд шинэ тоног төхөөрөмжид сургаж мэргэжүүлэх сургалт үйлдвэрлэгчийн зүгээс тасралтгүй зохион байгуулагдаж байна.	90%	EUR	7.000.000	5

EUR	10.000.000	Эрүүл мэндийн сайд, Н.Эрдэнэхүү (ХСҮТ-ийн Ерөнхий захирал)	Хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн тогтолцоог бүрдээгүйгээс орон нутагт хавдрын эрт илрүүлгийн чадамж сул, нийт хорт хавдрын 70 гаруй хувь нь хожуу үе шатандаа оношилогдож байна. Үүнтэй холбоотой хорт хавдартай өвчтөнүүдийн 5 ба түүнээс дээш амьдрах жилийн үзүүлэлт манай улсад 28.6 хувьтай байхад хөгжингүй орнуудад энэ үзүүлэлт 41 хувьтай байна.	Энэ онд 2 удаагийн худалдан авах үйл ажиллагааны төндөр зарласан боловч тендер шалгаруулалтын нөхцлийг хангаагүйтэй холбоотой дахин зарлахаар төлөвлөгдсөн.	5%	EUR	0	6
EUR	7,000.00	М.Минжмаа (ХСҮТ-ийн ТЭТ-ийн эрхлэгч)	Хавдрын туяа эмчилгээний эдийн засаг болон техникийн тооцооллыг бодитой гаргаснаар туяа эмчилгээний цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох нь тусламжийн хүлээгдлийг бууруулахад чухал ач холбогдолтой.	Туяа эмчилгээний хүртээмж, хүлээгдлийг тодорхойлохоор дата цуглуулж, боловсруулалт хийгдэж байна.	100%	EUR	7,000.00	7

